

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр хяналтад авч, гүйцэтгэлийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 зорилго, 3 зорилтын 4 арга хэмжээний 18 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явц 88.9 хувиар үнэлэгдэв.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгтгэл

№	Арга хэмжээ	Үнэлгээ (хувь)
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.		
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:		
4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.		
1.	Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх	90
2.	Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх	100
3.	Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах	100
4.2.1. үнэлгээний хувь		96.6
4.2.11. Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд		

үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.		
4.	Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах	70
5.	Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах	70
6.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах	70
7.	Ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах	100
8.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхайн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл хийх	50
9.	"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг үргэлжлүүлэх	100
10.	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах	100
11.	Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	90
12.	Дорноговь аймагт "Алтанширээт" аж үйлдвэрийн парк байгуулах	70
13.	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын ""Гэрэлт говь" кокс, металлургийн үйлдвэр" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах	70
14.	Гангийн үйлдвэр байгуулах	90
15.	Газрын тос боловсруулах үйлдвэр барих	70
16.	Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх	90
4.2.11. үнэлгээний хувь		80.0
Зорилт 4.6. Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ:		
4.6.1. Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна.		
17.	Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулан, хэрэгжүүлж эхлэх	100
Зорилго 6. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.		
Зорилт 6.2. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно:		
6.2.4. Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ.		
18.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	90
Зорилт 6.2. үнэлгээний хувь		90
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын үнэлгээний дүн		88.9

1. “Агаарын геофизик-2024” агаарын геофизикийн судалгааны ажлын төлөвлөлт болон зохион байгуулалтад алдаа гарсанаас удаашралтай байна.

2. Эрчимжүүлэх шаардлагатай, бүрэн хэрэгжээгүй дараах арга хэмжээ байна. Үүнд:

- “Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах”
- “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах”,
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхайн-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг байгуулах”,
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхайн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл хийх”,
- “Дорноговь аймагт “Алтанширээт” аж үйлдвэрийн парк байгуулах”,
- “Дорноговь аймгийн Хөвсгөл сумын “Гэрэлт говь” кокс, металлургийн үйлдвэр” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах”,
- “Гангийн үйлдвэр байгуулах”

3. Хэрэгжилтийг тайлагнахдаа гарсан үр дүнгийн талаар товч, тодорхой, оновчтой тайлагнахгүй байна.

4. Арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрэхгүй байгаа нь санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэхгүй, удаашралтай байдал нөлөөлж байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Арга хэмжээг төлөвлөхдөө шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинд тулгуурлан оновчтой, зөв тодорхойлж төлөвлөх;

2. Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжихгүй байгаа шалтгааныг тогтоох, эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах;

3. Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээ тус бүрээр иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, товч тодорхой, 2000 тэмдэгтэд багтаан уншиж ойлгоход хялбар, агуулгыг зөв тодорхойлж, тоо болон чанар, үр дүн, хүрсэн түвшингээр тайлагнах, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан нөхцөлийг дурдах.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ӨНӨРНАСАН

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТТУУЛ